



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАРТ**

2022.05.09 № 1/53.
танай _____ -ны № _____ -т

**Аудитын зөвлөмж
хүргүүлэх тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаал, Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн, үр ашиг”-т гүйцэтгэлийн аудит хийлээ.

Тус аудитаар илэрсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэй холбоотой зөрчлийг арилгуулахаар дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. ХАА-нд мөрдөх хугацааг төлөвлөхдөө ТАХ-ний цар хүрээ, онцлог шинж чанар, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, санхүүжилтийн хуваарь зэргийг харгалзан үзэж, төлөвлөгөөний дагуу ХАА-г зохион байгуулж байх;

Аудитын тайлантай танилцаж, тайланд дурдсан зөрчлийг арилган, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, үр дүнг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ж.Гантулга/-д зөвлөж байна.

Хавсралт... хуудас

ДАРГА



Р.МӨНХТОГТОХ

0012020981



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 194 А/126 0315-

Мандалговь

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үнэлгээний хорооны гишүүд “Өвөлжилтийн бэлтгэл хангах өвс, тэжээл бэлтгэх” багц тендерийн ажлын техникийн тодорхойлолтод бараа бүтээгдэхүүний тоо хэмжээг тусгаагүйгээс гүйцэтгэгч “Тааны амт” ХХК 2,468,000.00 /хоёр сая дөрвөн зуун жаран найман мянган/ төгрөгийн 200 боодол өвсийг дутуу нийлүүлсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т /Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана./, 47.2-т /Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дор дурдсан чиг үүрэгтэй байна./, 47.2.1-д /техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх./ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 тоот тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.9-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. ТАХ-ны худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж зөрчлийг давтан гаргахгүй байх;

Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ж.Гантулга, худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэн Б.Адъяасүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

/Д.ИХБАЯР/

БАТАЛГААЖУУЛСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Р.МӨНХТОГТОХ/

¹ Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70592208